



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 03

Эрдэнэбулган сум

Эмгэг судлалын шинжилгээнд  
хамруулах тухай

Аймгийн хэмжээнд 2020 оны 36 дугаар долоо хоногийн байдлаар нийт нас баралт 311 тохиолдол байгаагийн 52 нь эмнэлэгт, 259 нь гэрт нас барсан ба, хоног болоогүй нас баралт 18 байна.

Нийт нас баралтын 95 тохиолдол буюу 30.5 хувь нь задлан шинжилгээнд хамрагдсан, 216 тохиолдол буюу 69.5 хувь нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд хамрагдаагүй, мөн нас баралт бүрийг эмгэг судлалын болон шүүхийн шинжилгээний албаны задлан шинжилгээний хариу гармагц, өөрийн эмнэлэг дээрээ магадлан хэлэлцэх хурал хийж, дүгнэлт гарган, хурлын материалыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст ирүүлж байх албан бичиг хүргүүлсэн боловч, биелүүлэн ажиллахгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэн батлах тухай” А/55 тоот тушаалын хэрэгжилт хангалтгүй, мөн гэрийн нас баралтын тохиолдлуудыг шүүхийн шинжилгээний албаны задлан шинжилгээнд хамруулалт хангалтгүй байгаа нь харъяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарын ажлын хариуцлагатай шууд холбоотой юм.

Иймд нас барсан тохиолдлуудын оношийг баталгаажуулах, эмч, мэргэжилтний мэдлэг, хариуцлагыг дээшлүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж байгаа холбогдох тушаал, зааврыг хэрэгжүүлэн, хариуцлагыг сайжруулах зорилгоор ДААЛГАХ нь:

НЭГ. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, СУМ ДУНДЫН ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА НАРТ:

1.1.Эмнэлэгт нас барсан тохиолдол бүрийг /Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/55 тоот тушаалын 2.3-т зааснаас бусад/, Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлаач эмч дуудаж, эмгэг судлалын шинжилгээнд хамруулах,

1.2.Гэрийн нас баралтын тохиолдол бүрийг шүүхийн шинжилгээний албаны шинжээчийн баг дуудаж, задлан шинжилгээнд хамруулах,

1.3.Эрүүл мэндийн байгууллагууд нь, задлан шинжилгээний дүгнэлтийг эмгэг судлаач эмч болон шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмчээс хугацаанд нь гаргуулан авах,

1.3.Эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт гармагц, нас баралтын тохиолдол бүрийн шалтгааныг магадлан хэлэлцэх хурлыг өөрийн Эрүүл мэндийн байгууллага дээр чанартай, үр дүнтэй зохион байгуулж, дүгнэлт, шийдвэр гаргаж хэвших,

1.4.Нас баралтын шалтгааныг магадлан хэлэлцсэн хурлын тэмдэглэлийг улирал тутмын сүүлийн сарын 30-ны дотор Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст /[puujee770728@gmail.com](mailto:puujee770728@gmail.com)/ цахимаар ирүүлж байх,

1.5.Нас баралтын тохиолдол бүрийг эмгэг судлалын шинжилгээнд бүрэн хамруулах, эндэгдлийн шалтгааныг магадлан хэлэлцэх хурлыг шатлал бүрд чанартай, үр дүнтэй зохион байгуулж, хурлын материалыг хугацаанд нь Эрүүл мэндийн газарт ирүүлэхэд Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Н.Пүрэвдулам/ хяналт тавьж ажиллах.

ДАРГА  Р.ГАНДИЙМАА